



ТӨВ АЙМГИЙН
СЭРГЭЛЭН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
25р. ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2024 оны 05 сарын 06 өдөр

Дугаар 15

Эрдэнэ-Уул

Төслийг сонгон шалгаруулах хороо
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Хорооны дарга: Э.Лхагвадулам (Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: Ч.Хишиглхам (Төрийн сангийн мэргэжилтэн)

Д.Ариунзаяа (Төрийн бус байгууллагын төлөөлөл)

Ц.Жанцандолгор (Төрийн бус байгууллагын төлөөлөл)

Нарийн бичгийн дарга: М.Нандин-Эрдэнэ (Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн)

2. Журмын дагуу Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах тухай мэдээллийг хоршоо, жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд шуурхай хүргэж, төслийг сонгон шалгаруулахыг хорооны дарга (Э.Лхагвадулам), хорооны нарийн бичгийн дарга (М.Нандин-Эрдэнэ) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Т.БААСАНСҮРЭН